

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ УЛАМЖЛАЛ, АГУУЛГЫН ТУХАЙ

Ж.БАТНЯМ

ДХИС-ийн Удирдлагын академийн магистрант, дэд хурандаа

В.ПҮРЭВБААСАН

ДХИС-ийн Хилийн албаны удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор, доктор(Ph.D), хурандаа

Товч агуулга: Энэхүү сэдвийн хүрээнд Хил Хамгаалах Байгууллагаас Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын харилцан ажиллахад харилцан ажиллагааны агуулга, уламжлалыг судлан, онцгой нөхцөл байдлын үед анхаарах зарим санал дэвшүүлэхийг зорилоо.

Түлхүүр үгс: Хил хамгаалах байгууллага, харилцан ажиллагаа, агуулга, онцгой нөхцөл байдал, анхаарах асуудал.

Оршил

Хил Хамгаалах Байгууллага Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Хилийн тухай хуулинд зааснаар, хилийн аюулгүй байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэн ажиллаж ирлээ.

“Төрийн хилийн бодлого” гэдэг нь хилийн асуудлын хүрээнд төр өөрийнхөө зорилт чиг, үүргийг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа юм.¹ хэмээн тодорхойлжээ. Монгол улсын хил хамгаалах бодлого нь төрөөс хилийн талаар баримтлах бодлогоор илэрхийлэгдэн гардаг. Энэ бодлогын баримт бичиг нь Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг батлах тухай² 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 20 дугаар тогтоолоор батлагдсан.

Хилийн орон зайд Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын харилцан ажиллах хэрэгцээ шаардлага сүүлийн жилүүдэд улам ихээр нэмэгдэж байна.

Үндсэн хэсэг

Хилийн аюулгүй байдлын тухай ойлголт нь

Монгол Улсын хилтэй шууд холбогддог, орон зайн хувьд зохих хязгаарлалттай байдаг. Тиймээс Хилийн аюулгүй байдал нь тодорхой орон зай (хилийн орон зай) дахь үндэсний ашиг сонирхлын аюулгүй байдлаар голчлон тодорхойлогдож, аюулгүй байдлын бусад бүрэлдэхүүнд шууд нөлөөлж байдаг. Иймд улсын хилийн аюулгүй байдлыг хангахад анхаарах, улсын хил болон хил орчмын нутаг дэвсгэрт явагддаг тэрхүү нийгмийн ба хилийн харилцааны талаарх ойлголтыг дараах байдлаар авч үзэж болно. Улсын хил нь үндэсний гэхээсээ илүү олон улсын шинж байдлыг хадгалдаг онцлогтой. Монгол Улсын хил нь тус улсын хил гэж ойлгогддог боловч бодит байдал дээр Монгол-Орос, Монгол-Хятадын хоёр улсын агуулгатай хил болдог. Тогтоогдсон улсын хил нь яах аргагүй хоёр талын үндэсний язгуур эрх ашигтай холбогдсон байдаг. Улсын хил нь халдашгүй дархан байснаар зөвхөн Монгол Улсад бус мөн хөрш улсын аюулгүй байдалд ч эерэгээр

¹Дэслэгч генерал Ш. Арвай “МУ-ын Төрийн хилийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий хөтөлбөр” 1998

²Монгол улсын Их хурлын 2002 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 20 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”

нөлөөлөх хүчин зүйл бүрэлдэх таатай нөхцөл бий болж байгаагаар холбогдолтой. Хилийн аюулгүй байдлыг онолын хувьд “Монгол Улсын хилийн орон зайд төр, нийгэм, иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах ашиг сонирхол баталгаатай хангагдсан байгаагаар илэрнэ” гэж үздэг.

Хилийн аюулгүй байдал дараах арга хэмжээг авсан байдлаар хангагдана гэж үзэж байна. Үүнд:

- Хөрш улстай сайн хөршийн найрсаг харилцаа, энх тайван, хамтын ажиллагааг хөгжүүлэх, хилийн орон зайд олон улсын эрх зүйн зарчмуудыг хэрэгжүүлсэнээр;

- Хувь хүн, хуулийн этгээдээр хилийн болон хил орчмын дэглэм, боомтод мөрдөх журмыг сахиулснаар;

- Монгол Улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг сахин хамгаалснаар;

- Хилийн аюулгүй байдлыг хангахад Үндэсний Аюулгүй Байдлыг Хангах Тусгайлсан Чиг Үүрэгтэй байгууллагууд, төрийн захиргааны болон бусад байгууллагуудын хүч хэрэгслийг нэгтгэн ажиллуулснаар тус тус бүрдэнэ.

Туршлага, сургамж.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын харилцан хамтарч ажиллаж ирсэн уламжлал нь 1933 онд “Хязгаарын цэрэг” гэж байгуулагдсан цагаасаа эхлэн тухайн үеийнхээ Монгол Ардын цэргийн анги салбарууд, Нийгмийг аюулаас хамгаалах яамны харъяа бусад байгууллагууд, сум орон нутгийн засаг захиргааны нэгжүүдтэйгээ харилцан ажиллагааг зохион байгуулж байсан баялаг түүхтэй билээ. Харилцан ажиллагаа нь Хилийн хэсэгт бий болсон гамшиг, аюулт үзэгдэлтэй тэмцэх хариуцсан хэсгийн хил хамгаалалтыг тасралтгүй явуулах, тухайн нөхцлийг далимдуулан гарч болох хилийн

зөрчил, будлианаас урьдчилан сэргийлэх, бие бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах, бий болсон гамшиг, аюултай тэмцэх, түүний хор хөнөөлийг арилгахад чиглэгдсэн зайлшгүй гүйцэтгэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирсэн. Хилийн хэсэгт гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон, түүнд хилчид, хил хамгаалах байгууллагын байрлал, эд хөрөнгө, инженер техникийн байгууламж өртсөн тохиолдолд түүнтэй тэмцэх ажиллагаанд хилийн отряд оролцож, мэргэжлийн болон Улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх онцгой байдлын томилгоот анги салбаруудын хүч, оролцоог өргөнөөр ашигладаг.

Харилцан ажиллагааны агуулга. (Гамшгаас хамгаалах арга хэмжээний үед)

Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах арга хэмжээ гэдэг нь гамшиг тохиолдсон үед Засгийн газар, яам, агентлаг, байгууллага, орон нутаг, хувь хүмүүс гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг яаралтай зохион байгуулах бэлтгэлийг хангахад чиглэгдсэн арга хэмжээг урьдчилан авч хэрэгжүүлэхийг хэлнэ.

Бэлэн байдлыг хангах арга хэмжээнд гамшигтай тэмцэх төлөвлөгөө боловсруулах, хүч хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, бие бүрэлдэхүүнийг сургах арга хэмжээнүүд хамрагдана. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах ажилд байгууллага аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог дээшлүүлэх нь гамшгийн улмаас үүсэж болзошгүй хохирлыг бууруулахад 1. Үүрэг, 2. Зааг, 3. Цаг хугацаагаар уялдуулсан хатуу хязгаар зарчимтай байдаг. Тэгвэл харилцан ажиллагаа нь тус тусын ажлын зарчим, шийдвэр, арга тактик, хүч хэрэгсэл, нөхцөл бололцоогоороо байнга холбогдож байдаг идэвхтэй зайлшгүй хамтрах, хамтарч ажиллах ажиллагаа бөгөөд

үйл ажиллагааны үндэстэй хийгдэх ёстой.

Харилцан ажиллагааны үндэс гэдэгт харилцан ажиллагааны хэлбэр, түүнийг дэмжих, субъект, объект, арга зүй, зорилго, агуулга, төрөл, цар хүрээ, арга хэмжээ, үйл ажиллагаа зэрэг ордог байна. Түүнээс гадна харилцан ажиллагааны үндэст мэдээллийн нууцлал, хамгаалалтыг хамруулах нь зүйн хэрэг. Хүчээ төвлөрүүлэх чиглэлд хүч хэрэгслээ ашигласан хамтын арга хэмжээний зорилго агуулгыг тухай мэдээний нууцлалыг хадгалах үүднээс гүйцэтгэх Засгийн хэмжээнд харилцан ажиллагаатай байгууллагууд нь харилцан ажиллагааны тухай мэдээллийн нууцлал, хамгаалалтын талаар боломжит бүхий л арга хэмжээг авах хэрэгтэй. Харилцан ажиллагаа нь хүрээлэн буй орчноос ангид хэрэгжихгүй. Түүнд улс төр, нийгэм, эдийн засаг, эрх зүй, цэрэг, байгаль орчин зэрэг хүчин зүйлс нөлөөлөх болно. Харилцан ажиллагаа нь захиргаа, албаны үйл ажиллагааны хэлбэр, төрөл, чиг үүргийг тодорхойлсон олон талт төлөвлөгөөг биелүүлэх зорилгоор зохион байгуулагдаж байна. Энэ нь хилийн төлөөлөгчийн үйл ажиллагаа, материал техникийн хангалт, хилийн дэглэмийн хэрэгжилт, эрх зүйн, хүмүүжлийн ажил, хяналт, болон бусад хангалт гэсэн оперативын байгууллагуудын харилцан ажиллагааны тухай яриа юм.

Харилцан ажиллагааны агуулга нь: зохих объект руу чиглэсэн харилцагч субъектуудын бодит үйл ажиллагаа юм. Тийм үйл ажиллагаа нь янз бүрийн түвшинд янз бүрийн арга, хэлбэрээр хэрэгжинэ. Харилцан ажиллагааны хэлбэрт цагийн байдлын дүн шинжилгээ, янз бүрийн ажиллагаа, арга хэмжээний хамтарсан төлөвлөгөө, хүч хэрэгслээ харилцан ашиглах, шат шатны захирагдах байгууллагуудын

харилцан мэдээлэл, удирдлагын түр байгууллагыг харилцан илгээх (шуурхай бүлэг) оперативын болон албаны туршлага солилцох, улсын хилийн орчим болон хилийн шалган нэвтрүүлэх боомт дээр зөрчил гарахаас сэргийлэх талаар харилцан ажиллах зэрэг болно. Харилцан ажиллагааны байгууллагуудын үндсэн аргуудад зөвшилцөл, заавар, зохицуулалт, ажиллагаа, оновчтой харилцааг тогтоох зэрэг багтана.

Харилцан ажиллагаа нь хил дээр цагийн байдлын болзошгүй өөрчлөлт, нөхцөл байдлын өрнөлийн хамгийн магадлалт хэд хэдэн хувилбарт харилцан ажиллагааг байнга дэмжин цаг хугацаанд нь зохион байгуулна. Харилцан ажиллагааны асуудлуудыг үйл ажиллагааны үндсэн төрлөөр боловсруулна. Үүнд: цэргийн, оперативын (тагнуул, сөрөг тагнуул, эрлийн үеийн), эрх зүй, цэрэг-техникийн, хилийн төлөөлөгчийн гэх мэт.

Харилцан ажиллагаа болон аливаа ажиллагааны төрөлд дараах шаардлага тавигдана. Үүнд: тасралтгүй, уян хатан, зорилго тэмүүлэлтэй, идэвхтэй, далд, тодорхой, шаргуу байна.

а). Харилцан ажиллагааны тасралтгүй байх нь түүнийг зохион байгуулах хэрэгжүүлэх нэг үндсэн шаардлага юм. Тавигдсан үүрэг гүйцэтгэх цаг хугацааны туршид ажиллагааны байнгын зөвшилцөлийг хангаснаар түүнд хүрнэ.

б). Харилцан ажиллагааны уян хатан байдал нь цагийн байдлын өөрчлөлт эсвэл улсын хил хамгаалах үүрэг гүйцэтгэх явцад өөрчлөлт, тодотгол хийх боломж.

в). Харилцан ажиллагааны зорилго тэмүүлэл, идэвхтэй байдал нь гол үүрэг шийдвэрлэхэд захиргааны, хилийн болон байгууллагуудын арга хэмжээг шаргуу шийдвэртэй авч хэрэгжүүлэхэд явдал юм. Зорилго

тэмүүлэл, идэвхтэй байдал нь улсын хил хамгаалах бодлого, харилцан ажиллах субъектуудын зорилт, харилцан ажиллах талуудын өргөн санаачилга, хүч хэрэгслийн сонголттой уялдан түүний зохион байгуулалтыг төвлөрүүлэхэд оршино.

Дүгнэлт

Үндэсний Аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагууд өөрсдийн чиглэлээр харилцан ажиллагааг явуулдаг бөгөөд хоорондын уялдааг сайжруулах чиглэлээр зохих шатны арга хэмжээнүүдийг авч явуулсаар ирсэн. Гэвч нөхцөл байдлын өөрчлөлт илүү хурдтай түргэн шуурхай мэдээлэл солилцох, үр ашигтай байдлыг шаардсаар байна.

Улсын хилийн аюулгүй байдлын түвшин (хил хамгаалалтын найдвартай байдал) нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт нөлөөлж болох гадаад, дотоод аюул заналаас хувь хүн, нийгэм, төрийн язгуур ашиг сонирхол хэрхэн хамгаалагдсан байдлаар илэрхийлэгдэж байна. Хилийн аюулгүй байдлын хамгаалалт нь; олон талт цогц шинж чанарыг агуулах бөгөөд тусгайлсан чиг үүрэг бүхий субъектүүдийн үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах шаардлагатайг харуулж байна. Терроризм, хар тамхи мансууруулах бодис наймаалах, хүн худалдаалах, мөнгө угаах зэрэг шинэ төрлийн гэмт хэргүүд, гамшигт үзэгдэлүүд улс дамжин гарч, учирч буй хохирлын хэмжээ жил ирэх бүр нэмэгдэж, хүндэрч байгаа нь Үндэсний Аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, боловсон хүчин, техник технологийн шинэчлэлтүүдийг хийх цаг хугацааны орон зайн зүй ёсны шаардлагатай тулгарч байна.

Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах нь улс оршин тогтнохын аюулгүй байдлыг

хангах гол хүчин зүйл бөгөөд энэ нь зөвхөн үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллага, цөөн хэдэн хүн хүчний оролцоотой ажил биш бөгөөд нийт ард иргэдийн оролцоотой хийгдэх ажил гэдгийг ард иргэдэд ойлгуулах, сурталчлах ажил чухал байна. Хил орчмын нутаг дэвсгэрт гарсан ой хээрийн түймэр, гамшигт үзэгдэлүүдийн талаар цаг тухайд нь мэдээ, мэдээлэл солилцон харилцан ажиллагааг зохион байгуулан явуулснаар зөвхөн түймрийн үед гэхэд галын тархацыг бууруулах, цаашид учрах хохирлын хэмжээг багасгахад чухал нөлөө үзүүлнэ. Иймд хил хамгаалах байгууллагын хэмжээнд ой хээрийн түймрийн үед ажиллах төлөвлөгөө, сургалт, ард иргэд, орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагаагааг хил хамгаалах албаны үйл ажиллагааны бэлэн байдал, гамшгаас хамгаалах бэлэн байдлуудын хүрээнд удирдлагын үйл ажиллагааг тодотгох шаардлагатай.

Санал

Гамшгийн эрсдэл, үр дагаврыг бууруулах зорилтын хүрээнд хил орчмын нутаг дэвсгэрт болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээг хүргэх болон солилцох шинэ боломжийг бүрдүүлэх, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангахад чиглэгдсэн хамтын менежмент, чадавхийг бэхжүүлэх;

Гамшгийн хор хөнөөлийг арилгах, гамшгийг арилгах, аврах ажиллагаанд хил хамгаалах болон орон нутгийн онцгой байдлын нэгжтэй харилцан ажиллах чадавхийг дээшлүүлэх зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт

- Ш.Арвай “Монгол Улсын Төрийн хилийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий хөтөлбөр” 1998

- Монгол Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого